

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... сарын
.....-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

“12.2.Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлал нь дор дурдсан хууль тогтоомжийн төсөл **боловсруулахад** хамаарахгүй.”

12.2.1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.1-д заасан хууль тогтоомжийн төсөл;

12.2.2.Дайны байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Дайн бүхий байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д тус тус заасан Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл;

12.2.3.Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.1, 3.4.3-т заасан хууль тогтоомжийн төсөл;

12.2.4.тухайн жилийн төсвийн тухай;

12.2.5.төсвийн хүрээний мэдэгдэл;

12.2.6.олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах тухай;

12.2.7.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай;

12.2.8.Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх тухай;

12.2.9.төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай;

12.2.10.энэ хуулийн 6.2, 6.3-т заасан тогтоолын төсөл;

12.2.11.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төсөл батлах тухай;

12.2.12.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай;

12.2.13.улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай;

12.2.14.хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн төсөл батлах тухай;

12.2.15.улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай;

12.2.16.төрөөс мөнгөний талаар тухайн жилд баримтлах үндсэн чиглэл батлах тухай.

12.1.17.албан тушаалтныг томилох, чөлөөлөх тухай.

2/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:

“12.3.Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-д заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал нь дор дурдсан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй.

12.3.1.тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулах шаардлагатай болохыг Үндсэн хуульд онцлон заасан бол;

12.3.2.Монгол Улсын олон улсын гэрээгээр Монгол Улс тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах талаар тусгайлан үүрэг хүлээсэн бол;

12.3.3.Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийсэн үнэлгээгээр тухайн хуулийг шинэчлэн найруулах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан бол.”

3/15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсэг:

“15.10.Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлуулахаар хүргүүлэхдээ хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан болон хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн талаарх холбогдох баримт бичгийн судалгаа, үнэлгээний тайлангийн хамт ирүүлнэ.”

4/20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсэг:

“20.12.Төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авахаар ирүүлэхдээ хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, зардлын тооцоог хийсэн талаарх холбогдох баримт бичгийн хамт ирүүлнэ.”

5/22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт:

“22.1.5.хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.”

6/26¹ дүгээр зүйл

“26¹ дүгээр зүйл. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.

26.1.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг хүчингүй болгосноор өмнө нь хүчингүй болсон хуулийн үйлчлэл сэргэхгүй.”

7/38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг:

“38.8.Энэ хуулийн 12.2-т заасан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно.”

8/40 дүгээр зүйлийн 40.1.11 дэх заалт:

“40.1.11.энэ хуулийн 15.10, 20.12-д заасан баримт бичиг”

9/49 дүгээр зүйлийн 49.9 дэх хэсэг:

“49.9.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу дараахь зорилгоор үнэлж, санал дүгнэлт, зөвлөмж гаргана:

49.19.1.хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах;

49.10.2.хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох;

49.10.3.зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох.”

2 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “судлах” гэсний дараа “, эсхүл тухайн харилцааг зохицуулж байсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” гэж, 41 дүгээр зүйлийн 41.5 41.6 дахь хэсгийн “дүгнэлт” гэсний өмнө “эрх зүйн” гэж, мөн зүйлийн 41.7 дахь хэсгийн “дүгнэлтийг” гэсний өмнө “эрх зүйн” гэж, 49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “, төрийн захиргааны байгууллага” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалт:

“13.2.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцэх эсэхийг судлах;”

2/13 дугаар зүйлийн 13.2.6 дахь заалт:

“13.2.6.Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлын талаарх бусад улсын эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа хийсэн байх;”

3/15 дугаар зүйлийн 15.7.2 дахь заалт:

“15.7.2.хуулиар тогтоосон эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудал.”

4/17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг:

“17.2.Энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг дараахь зорилгоор үнэлж, санал дүгнэлт, зөвлөмж гаргана.”

5/21 дүгээр зүйлийн 21.13 дахь хэсэг:

“21.13.Засгийн газар энэ хуулийн 21.1-д заасан хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцээгүй, энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргаж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо уг дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна.”

6/30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсэг:

“30.7.Хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо нь тодорхой утга агуулгаар зөвхөн нэг бүлэг, зүйл, хэсэг, заалтын хүрээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлт, тайлбарыг холбогдох бүлэг, зүйлийн, хэсэг, заалтын ард байрлуулж болно.”

7/33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалт:

“33.2.1.хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын зохицуулалтын талаар;”

8/40 дүгээр зүйлийн 40.1.8 дахь заалт:

“40.1.8.энэ хуулийн 15.2-т заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлсэн тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвлөмж;”

9/49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг:

“49.5.Улсын Их Хурал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний бүтцийн нэгж нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний дүнг хууль санаачлагчид мэдээлнэ.”

10/52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг:

“52.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээг хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд, эсхүл шаардлагатай тохиолдолд хийнэ.”

4 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 46.1, 46.2, 46.3 дахь хэсгийн “таниулах” гэснийг “сурталчлах” гэж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “хэрэгжилтэд хяналт шинжилгээ,” гэснийг “хэрэгжилтийн үр дагаварт” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “мэргэжилтнийг” гэснийг “албан тушаалтан, судлаач, эрдэмтэн” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “мэргэжилтнээс” гэснийг “албан тушаалтан, судлаач, эрдэмтнээс” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “зохицуулна” гэснийг “судалж, санал дүгнэлт, зөвлөмж гаргана” гэж, мөн зүйлийн 13.2.2 дахь заалтын “хууль тогтоомжоор” гэснийг “эрх зүйн хэм хэмжээгээр” гэж, мөн зүйлийн 13.2.3 дахь заалтын “шийдвэрлэх зохицуулалтын хувилбаруудыг” гэснийг “зохицуулах эрх зүйн хэм хэмжээг” гэж, мөн зүйлийн 13.2.4 дэх заалтын “зохицуулалтын хувилбарын” гэснийг “зохицуулах эрх зүйн хэм хэмжээний” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “судалсны үндсэн дээр” гэснийг “судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай” гэснийг “тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй” гэж, мөн зүйлийн 15.4 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллагууд нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай” гэснийг “Засгийн газрын гишүүд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй” гэж, мөн зүйлийн 15.5, 15.6 дахь хэсгийн “төрийн захиргааны төв байгууллагатай” гэснийг “Засгийн газрын гишүүдтэй” гэж, мөн зүйлийн 15.7, 15.8 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Засгийн газрын гишүүн” гэж, 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийн “Төрийн захиргааны төв байгууллагаас” гэснийг “Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс” гэж, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийн “төрийн захиргааны төв байгууллагад” гэснийг “Засгийн газрын гишүүнд” гэж, мөн зүйлийн 20.7 дахь хэсгийн “Засгийн газрын санаачилсан” гэснийг “энэ хуулийн 20.4-т заасны дагуу холбогдох Засгийн газрын гишүүнээс ирүүлсэн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.9.1 дэх заалтын “Үндсэн чиглэлд” гэснийг “бусад хуульд” гэж, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийн “хэлбэрт оруулж байрлуулна” гэснийг “дарааллаар байрлуулна” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “Хууль” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол хууль” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтын “судалгааны тайлан” гэснийг “холбогдох бусад баримт бичиг” гэж, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга” гэж, Наймдугаар бүлгийн гарчгийг “Хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх, олон нийтэд сурталчлах” гэж, Аравдугаар бүлгийн гарчгийг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” гэж, 49 дүгээр зүйлийн гарчиг, 49 дүгээр зүйлийн 49.7 дахь хэсгийн “хяналт шинжилгээ,” гэснийг “үр дагаварт хийсэн” гэж, мөн зүйлийн 49.2, 49.3 дахь хэсгийн “хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ,” гэснийг “хууль тогтоомжийн үр дагаварт хийх” гэж,

мөн зүйлийн 49.4 дэх хэсгийн “хяналт шинжилгээ,” гэснийг “үр дагаварт” гэж, 49 дүгээр зүйлийн 49.8 дахь хэсгийн “хяналт шинжилгээ, үр дагаврын” гэснийг “үр дагаварт” гэж, 52 дугаар зүйлийн гарчгийн “хяналт шинжилгээ, үр дагаврын” гэснийг “үр дагаварт хийсэн” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа” гэснийг, мөн зүйлийг 20.7 дахь хэсгийн “эцэслэн” гэснийг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “хуулийг бүхэлд нь,” гэснийг, 24 дүгээр зүйлийн 24.5.4 дэх заалтын “хууль,” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсгийн “хяналт шинжилгээ” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.11 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, 48 дугаар зүйл, 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсэг, 50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг